



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг.

Утас/Факс: (976) 7042-2954

E-mail: bayanulgiu@audit.gov.mn

2023.02.24 № 236

танай _____-ны № _____-т

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ш.МАРАТ ТАНАА**

Танай байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг, албан шаардлагын хамт хүргүүлж байна. Албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь ирүүлнэ үү.

Хавсралт 29 хуудастай.



**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ХУАНГАН**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.МАРАТ ТАНАА

доав.од. 24 № 230
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН





БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 87/ББА-2023/08/КА-СТА-ТЧЗ

Өлгий

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Грийн-Элдорадо" ХХК-тай 2021 оны 10-р сарын 14-ний өдөр гэрээ байгуулж, гоёл чимэглэл болон жимсний модны 9 төрлийн 1107 ширхэг суулгацыг 10,000.0 мянган төгрөгөөр худалдаж авахаар 9,900.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч гэрээнд суулгацын үнийг нэр төрлөөр нь тодорхой тусгаагүй, 1107 ширхэг суулгацыг хүлээж авсныг нотлох орлогын баримт, нийлүүлсэн компанийн зарлагын баримтгүй, орлого авч данс бүртгэлд тусгаагүй, суулгацыг байгууллагуудад тараасан жагсаалт, нотлох баримтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчжээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, бүрдэл дутуу баримтаар хөрөнгө зарцуулсан зөрчлийг арилгах;

2. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 06-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 5 дугаар баг, ЗДТГ-ын байр 1 дүгээр давхар. Утас: 70422954, 70422930

3. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Ш.Марат, нягтлан бодогч Х.Тилеухан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР  У.ЕРБОЛ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

8717144071
БЮА0074 9007245

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
2023 оны-р сарын ...-ны өдрийн
дугаар албан шаардлагын хавсралт

төгрөгөөр/

/мянган

№	Зөрчлийн утга	Мөнгөн дүн
1	9 төрлийн 1107 ширхэг суулгацыг 10,000.0 мянган төгрөгөөр худалдаж авахаар 9,900.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч гэрээнд суулгацын үнийг нэр төрлөөр нь тодорхой тусгаагүй, 1107 ширхэг суулгацыг хүлээж авсныг нотлох орлогын баримт, нийлүүлсэн компанийн зарлагын баримтгүй, орлого авч данс бүртгэлд тусгаагүй, суулгацыг байгууллагуудад тараасан жагсаалт, нотлох баримтгүй байна.	9,900.0
	Нийт дүн	9,900.0

Хавсралтыг үйлдсэн: Ахлах аудитор



У.Ербол

Танилцсан: Нягтлан бодогч



Х.Тилеухан